

МОНГОЛ УЛС, УКРАИН УЛС ХООРОНД ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦАА ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Украин Улсын Ерөнхийлөгч Виктор Януковичийн урилгаар 2011 оны 6 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Украин Улсад төрийн айлчлал хийв.

Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Украин Улсын Ерөнхийлөгч Виктор Януковичтай ганцаарчилан уулзаж, хоёр талын албан ёсны төлөөлөгчдийн хамт хэлэлцээ хийв. Украин Улсын Дээд Рада (парламент)-ын дарга Владимир Литвин, Украин Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжил, худалдааны сайд Андрей Ключев нар тус тус түүнд бараалхаж, хоёр улсын Төрийн тэргүүн нар монгол, украины бизнес форумд оролцов. Мөн айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Львов хотод зочлов.

Хоёр улсын Төрийн тэргүүн нар нөхөрсөг, илэн далангүй байдалд Монгол, Украины дотоод улс төр, нийгэм, эдийн засгийн байдлын талаар харилцан мэдээлж, хоёр улсын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн төлвийн талаар, түүнчилэн харилцан сонирхсон олон улсын болон бүс нутгийн өргөн хүрээтэй асуудлаар санал солилцов.

Хоёр улсын Төрийн тэргүүн нар Монгол, Украины он удаан жилийн нөхөрсөг харилцааг өндрөөр үнэлж, хоёр орны удирдлага, ард түмэн түншлэлийн хэлхээ холбоогоо цаашид бүх талаар хөгжүүлэн бэхжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болохыг нотлов.

Хоёр удирдагч 2011 оны нэгдүгээр сарын Давосын (Швейцарь Улс) Эдийн засгийн чуулга уулзалтын үед эхлэл нь тавигдсан хоёр талын дээд түвшний уулзалтын эерэг өрнөлийг тэмдэглэв. Хоёр орны Төрийн тэргүүн нар хоёр талын нөөц боломжийг дээд зэргээр ашиглан Монгол, Украины олон талтай хамтын ажиллагаа бүхий түншлэлийг цаашид хөгжүүлэхэд бэлэн болохоо нотлон, дэлхий нийтийг хамарсан сорилтуудыг сөрөн зогсоход хүчин чармайлтаа нэгтгэхийн төлөө байгаагаа илэрхийлж, ярьж хэлэлцсэн олон улсын харилцааны олон асуудлаар нэгдмэл ойлголцолд хүрэв.

Монгол Улс, Украин Улсын Ерөнхийлөгч нар (цаашид Талууд гэх) хоёр талын хамтын ажиллагааг идэвхжүүлэх нийтлэг эрмэлзэлд тулгуурлан дараах мэдэгдлийг хийв:

1. Талууд улс хоорондын хэлхээ холбоо сэргэж буйд баяр хүргээд, дээд, өндөр хэмжээнд харилцан айлчлалыг тогтмолжуулах нь хоёр улсын харилцан ашигтай хамтын ажиллагааг улс төр, худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын болон бусад салбарт идэвхжүүлэн, Монгол, Украины хөгжлийн боломж, шаардлагад нийцүүлэн, үр өгөөжтэй болгоход тус дөхөм үзүүлнэ хэмээн санал нэгдэв.

2. Хоёр улсын Ерөнхийлөгч Монгол, Украины сонгон авсан хөгжлийн зам хийгээд бие даасан байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэж байгаагаа нотлов.

3. Талууд Монгол, Украины худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын ажлын үр өгөөжийг дээшлүүлэхэд бэлэн байгаагаа нотлохын хамт, хоёр талын харилцан ажиллагаанд тустай бусад механизмыг хөгжүүлэхэд бүх талаар тус дөхөм үзүүлэхээ нотлов.

4. Талууд Монгол, Украины төр, засгийн холбогдох байгууллагууд хамтын ажиллагааны нөөц боломжуудыг дүүрэн ашиглахгүй байгааг дурдаад, хөдөө аж ахуй, машины үйлдвэр, эрчим хүч, барилга болон ашигт малтмал хамтран ашиглах зэрэг хэтийн төлөв бүхий салбарт бизнесийнхнийг бүх талаар дэмжин, таатай нөхцлийг бүрдүүлэхийн чухлыг тэмдэглэв.

Хоёр улсын хооронд худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, юуны өмнө өндөр технологийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг өсгөх замаар бүтцийг нь сайжруулах нь чухал хэмээн санал нэгтэй үзэв.

5. Хоёр улсын удирдагчид шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, түүний дотор нисэх болон усан онгоцны үйлдвэрлэл, уул уурхайн олборлолтын чиглэлээр Украины шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн чадавхи болон дээрх салбарууд дахь Монголын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагыг харгалзан, мөн харилцан сонирхсон бусад салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хоёр талын хооронд яриа хэлэлцээ явагдаж эхэлснийг өндрөөр үнэлэв.

6. Талууд хоёр орны ажил хэрэгч хүрээний хооронд шууд харилцаа, яриа хэлцээг өргөжүүлэх шаардлагатайг тэмдэглээд, Монгол, Украины Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимдуудын хооронд Ажил хэргийн зөвлөл байгуулах эрмэлзэлтэй байгааг илэрхийлэв. Түүнчилэн Монгол, Украины өндөр түвшний уулзалт, арга хэмжээний үеэр хоёр талын бизнес уулзалтуудыг хойшид тогтмол зохион байгуулж байх нь чухал гэдгийг тэмдэглэв.

7. Хоёр Ерөнхийлөгч аюулгүй байдал, батлан хамгаалах салбар дахь хоёр талын хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэхийг дэмжиж, Монгол, Украины цэрэг, техникийн хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн Засгийн газар хоорондын комиссын түвшинд дагнасан механизм байгуулах шаардлагатай гэж үзэв.

8. Боловсролын салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд Украины их, дээд сургуулиудад нарийн мэргэжлээр монголчуудыг сургаж, мэргэжилтэн бэлтгэж ирсэнд Талууд сэтгэл хангалуун байгаа бөгөөд цаашид ч энэ чиглэлд хамтран ажиллах болов.

9. Хоёр улсын удирдагч нар Монгол, Украины харилцааны эрх зүйн үндсийг цаашид өргөжүүлэхийн чухалыг тэмдэглээд, айлчлалын үеэр дараах баримт бичгүүдэд гарын үсэг зурж буйг сайшаав. Үүнд:

- Боловсролын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, Украин Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр;
- Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Сайд нарын танхим хоорондын хэлэлцээр;
- Онцгой байдлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Сайд нарын танхим хоорондын хэлэлцээр;
- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Украины Засгийн газар хоорондын комиссын журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Протокол;
- Монгол Улсын ГХЯ, Украин Улсын ГХЯ хоорондын 2012-2013 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө.

10. Талууд Монгол Улсаас Украин Улсад сурч, хөдөлмөрлөж буй иргэд, Украинаас Монгол Улсад сурч, хөдөлмөрлөж буй иргэд нь хоёр орны ард түмний хоорондын уламжлалт харилцаа, харилцан ойлголцолыг гүнзгийрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж ирснийг тэмдэглээд, тэдгээр иргэд Монгол, Украины нутаг дэвсгэрт тав тухтай амьдрах, сурч, хөдөлмөрлөх нөхцлийг хоёр улсын хууль тогтоомжийн хүрээнд цаашид ч хангаж байхаар тохиров.

11. Дэлхий дахиныг хамарсан санхүү, эдийн засгийн хямралын үр дагавартай тэмцэх хүчин чармайлтаа нэгтгэсний үндсэн дээр дэлхийн эдийн засгийн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангах болно гэдгийг Монгол, Украины Ерөнхийлөгч нар хүлээн зөвшөөрөв.

Талууд байгаль, цаг уурын өөрчлөлт, мансууруулах бодис болон зэвсгийн хууль бус наймаа, ядуурал, эрүүлийг хамгаалах зэрэг дэлхий нийтийг хамарсан асуудлуудыг хойшлуулшгүй шийдвэрлүүштэй байгааг тэмдэглэв. Улс хоорондын зөрчилдөөнийг НҮБ-ын дүрмийг иш үндэс болгон, олон улсын эрх зүйн зарчимд тулгуурлан энхийн аргаар зохицуулахад болон олон улсын эдийн засаг, худалдаа, санхүүгийн шинэ дэг журмыг нийт улс орнуудын эрх ашигт нийцүүлэн шударга, эрх тэгш үндсэн дээр тогтооход Талууд олон улсын чуулга уулзалтуудын хүрээнд тус дөхөм үзүүлэхэд бэлэн байгаагаа нотлов.

12. Талууд терроризм, алан хядах, салган тусгаарлах үзлийн бүхий л хэлбэрийг эрс буруушааж, мөнгө угаах, терроризм, экстремизмийг санхүүжүүлэхийн эсрэг олон талт үйл ажиллагаа явуулах нь чухал болохыг цохон тэмдэглэв.

13. Зэвсэг хураах, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх, түүний дотор Цөмийн туршилтыг бүх нийтээр хориглох тухай хэлэлцээрийг

даруй хүчин төгөлдөр болгохын төлөөх хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар дэлхий дахинаа цөмийн аюулыг бууруулах шаардлагатайг хоёр Ерөнхийлөгч нотлов.

14. Талууд Нэгдсэн Үндэсний Байгууллага, түүний салбар байгууллагууд болон олон улсын бусад байгууллага дахь Монгол, Украины хамтын ажиллагааг нааштай үнэлэв. Хоёр улс XXI зууны дэлхийн хамтын нөхөрлөлийн шинэ нөхцөл байдалд тохируулан НҮБ-ын Аюулгүй Зөвлөлд зохион байгуулалтын өөрчлөлт хийх замаар түүний нэр хүнд, ажлын үр өгөөжийг нь дээшлүүлэхийн төлөө байна. Хөгжиж буй орнуудын ашиг сонирхлыг харгалзан үзэх, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хангалттай бус төлөөлөл бүхий бүсүүдийн улс орнуудад зохих анхаарал хандуулах нь эл байгууллагын шинэчлэл амжилттай хэрэгжих үндэс болох юм гэж Талууд үзэж байна.

15. Украины тал Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийг Украин Улсын Ерөнхийлөгч илэрхийлэхийн сацуу энэ чиглэлд Монгол Улсын олсон амжилтыг өндрөөр үнэлэв.

16. Монгол Улсын Ерөнхийлөгч халуун дотноор хүлээн авсанд нь Украин Улсын Ерөнхийлөгчид талархал илэрхийлж, тааламжтай үедээ Монгол Улсад төрийн айлчлалаар ирэхийг урив. Украин Улсын Ерөнхийлөгч урилгыг талархан хүлээн авав.

Киев хотноо 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдөр монгол, украин хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэн, гарын үсэг зурав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖ

УКРАИН УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
ВИКТОР ЯНУКОВИЧ